

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТЭД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

2024 оны 01 дүгээр сарын
03 ны өдөр

Улаанбаатар
хот

Нэг. Хяналт- шинжилгээ, үнэлгээний зорилго:

Төсвийн ерөнхийлөн захирагч /Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга/-аас төсвийн шууд захирагч /Аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн дарга/-тай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зорилт, арга хэмжээний гүйцэтгэл тус бүрийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг зорилтот түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, төлөвлөлт, биелэлт, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа нь үр дүнтэй байсан эсэхэд үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилт, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Арга зүй, ашигласан эх сурвалж:

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ыг удирдлага болгов.

Говьсүмбэр аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн даргын 2023 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг:

- Төсвийн шууд захирагчийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө;
- Төсвийн шууд захирагчийн зорилт, арга хэмжээний жилийн эцсийн хэрэгжилтэд өгсөн зохион байгуулалтын нэгжийн үнэлгээ;
- Тушаал шийдвэр, хугацаатай баримт, бичгийн биелэлтийн тайлан;
- Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ;
- Өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь чанартай биелүүлсэн эсэхэд үндэслэн арга хэмжээ, ажил үйлчилгээний шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшинтэй харьцуулан дүгнэв.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн:

Говьсүмбэр аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн даргын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилт 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Төсвийн шууд захирагчийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг харуулбал: